

**МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААР БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 6 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
А.Бакей**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн Малын индексжүүлсэн даатгалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2014 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хороо 2014 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хийлээ.

Хуралдаанаар хуулийн төслийн даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах зорилгоор малын хорогдлын нэгдүгээр босго үзүүлэлт нь зургаан хувь, хоёрдугаар босго үзүүлэлт нь 30 хувь байхаар хуульчлах, сумын малын хорогдлыг мэдээлэх, үүнтэй уялдуулан даатгалын эрсдэлийн түвшин, даатгалын хураамжийг тогтоох, давхар даатгалын компанийг төрийн болон хувийн өмчийн оролцоотой хувьцаат компани байхаар тогтоож, холбогдох зохицуулалтыг Компанийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөх, даатгалын тохиолдол, даатгалын эрсдэлийн хуваарилалт, нөхөн төлбөртэй холбогдсон зохицуулалтыг нэмж тусгах, түүнчлэн хамтын эрсдэлийн сан, давхар даатгалын сангийн зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбогдсон зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлтийг төсөлд тусгах асуудлаар санал хураалт явуулсан бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд даатгалд мал бүхий иргэн, хуулийн этгээдээс гадна малчныг хамааруулах нь зүйтэй, мөн “Нийслэлийн төвийн дүүргүүдийг нэгтгэн нэг сумтай, алслагдсан дүүрэг тус бүрийг нэг сумтай адилтган үзэж босго үзүүлэлтийг тогтооно” гэсэн заалтыг бүхэлд нь хасах нь зүйтэй гэсэн саналыг, Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл малын хорогдлын босго үзүүлэлтийг тогтоох гэсэн зүйлийн 1.1,1.2 дахь заалтуудад найруулгын шинжтэй засвар оруулах нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргасан.

Хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Дээрх хуулийн төслүүдийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Малын индексжүүлсэн даатгалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ  
АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА**



**Г.БАЯРСАЙХАН**